



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrtд.gov.mn, http://www.mrtд.gov.mn

2021. 01 15 № 03/190
танай 2020. 12. 17-ны № 03/2173 -т

┌ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ┐
АЖЛЫН АЛБАНД

Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх
Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
2020 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан,
холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: 33 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.12.31

1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил, үр дүн

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д төрийн байгууллага нь “төрийн албан хаагчийн сургалт, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх”-ээр заасны дагуу “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”, Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын “Сургалтын хөтөлбөр”-ийг 2017 онд тус тус шинэчлэн баталсан бөгөөд эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан ба төлөвлөгөөнд нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 93.55 хувийн биелэлттэй байна. /Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хавсаргав. Хавсралт 1/

3. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал

Тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны хуралдаанаар 5 асуудлыг хэлэлцэж, салбар зөвлөлийн дараахь нийт 13 тогтоолыг батлан гаргасан байна. Үүнд:

1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл
2. Төрийн албан хаагчдад зэрэг дэв олгох тухай
3. Зам, тээврийн хөгжлийн яамны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд сонгон шалгаруулалт зохион байгуулах үүрэг бүхий шалгалтын комиссын тайлан, дүгнэлтын талаар
4. Зам, тээврийн хөгжлийн яамны гүйцэтгэх албан тушаалд сонгон шалгаруулалт зохион байгуулах үүрэг бүхий шалгалтын комиссын тайлан, дүгнэлтын талаар
5. “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын хоол унааны мөнгийг “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу зөрүүг нөхөн олгох тухай гаргасан Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын гаргасан хүсэлтийн талаар”

Салбар зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг холбогдох салбар зөвлөлийн гишүүн, албан тушаалтанд өгч, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч, биелэлтийг тооцон ажиллаж байна.

/Салбар зөвлөлийн хуралдааны шийдвэр, түүний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав. Хавсралт 2/

4. Салбарын хэмжээнд хууль журам, заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхэд хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал, үр дүн

Тус яамны харьяа салбарын байгууллагууд нь улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар үйл ажиллагаа явуулдаг тул Төрийн албаны тухай хуулийн үйлчлэлд хамаарагдахгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаг болно.

Салбар, үйл ажиллагаа, мэргэжлийн онцлогоос шалтгаалж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын хувьд дарга, дэд дарга нь төрийн жинхэнэ албан хаагчид хамаардаг тул тухайн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, үнэлж дүгнэх зэрэг асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

5. Салбарын хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

5.1. Тус яамны харьяа Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төвд хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт-шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилон, хяналт шалгалтыг хийж дүгнэлтийг гаргаж танилцуулсан.

Тус яамны шалгалтын ажлын хэсгээс хүний нөөцийн томилгоо, хувийн хэргийн бүрдүүлэлт зэрэг холбогдох баримт бичигт үзлэг хийж, зөвлөмжийг хүргүүлсэн.

5.2. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайд Төрийн албаны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд холбогдох стандарт, дүрэм, журмыг мөрдөж, ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын хариуцлага, сахилга дэг журмыг чангатгаж, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг яамны харьяа байгууллагын дарга, захирал нарт 2020 оны “Сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай” А/01 дугаар тушаалаар үүрэг болгосон.

Тушаалын хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын газар харьяа байгууллагуудаас улирал бүр авч нэгтгэн тухай бүр үүрэг чиглэл өгч ажилласан бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн “Тушаалын хэрэгжилтийг хангуулж, үнэлгээ дүгнэлт өгч ажиллах тухай” удирдамжийн дагуу Ажлын хэсэг байгуулан харьяа байгууллагуудад төлөвлөгөөт бус шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Шалгалтын бүрэлдэхүүн дээрх үнэлгээнд үндэслэн цаашид авах арга хэмжээний саналыг “Зөвлөмж” хэлбэрээр боловсруулж яамны удирдлагуудад танилцуулан харьяа байгууллагуудын тайлангийн нэгдсэн хуралдааныг зохион байгуулсан.

Нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудыг нэгтгэн Зам, тээврийн хөгжлийн сайдын “Тушаалын хэрэгжилтийг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/202 дугаар тушаалыг батлуулан харьяа байгууллагуудад хугацаатай үүрэг өгч ажиллаа.

Зам, тээврийн хөгжлийн сайдын “Сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай” А/01 дугаар тушаал, “Тушаалын хэрэгжилтийг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/202 дугаар тушаалын Сахилга хариуцлагын хэрэгжилтийн үнэлгээ жилийн эцсийн байдлаар **97** хувьтай байна.

5.3.Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу Нийслэлийн авто замын хөгжлийн газар, Нийтийн тээврийн үйлчилгээний газарт Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан шалгалтын комисс батлагдсан удирдамжийн дагуу шалгалтыг зохион байгуулж шалгалтын үеэр нийт 11 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгч, зөвлөмж өгч ажилласан байна. Шалгалтын тайланг Төрийн албаны зөвлөлд 2020 оны 03/441 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

6. Төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн, Төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил

Зам, тээврийн хөгжлийн яамны болон харьяа байгууллагын албан хаагчдыг 2020 онд сургах сургалтын төлөвлөгөө яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгдүгээр хавсралтаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт зохион байгуулагдсан 15 төрлийн сургалтад давхардсан тоогоор 307 албан хаагчийг хамруулсан байна

Удирдлагын академийн 2020 онд улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөний дагуу Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 24, төрийн албан хаагчдын давтан сургалт-11, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт-4, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт-2, архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүйн богино хугацааны сургалтад -2, Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэглээ богино хугацааны сургалтад-1, Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй-2 нийт 48 албан хаагч суралцаж байгаагаас 40 албан хаагч сургалтын хуацаа дуусч “Сертификат”-аа авсан.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн сургалтын төлөвлөгөөний дагуу яамны болон яамны харьяа байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулах арга хэмээг зохион байгуулж Авлигын эсрэг сургалтад хамрагдах албан тушаалтнуудын нэгдсэн төлөвлөгөө гарган харьяа байгууллагад хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний дагуу яамны 14, харьяа байгууллагын 107, нийт 121 албан хаагчийг хамруулсан.

- Зам, тээврийн хөгжлийн яаманд шинээр томилогдсон 11 албан хаагч нарт зориулсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандарт” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Зам, тээврийн хөгжлийн яаманд шинээр томилогдсон 11 албан хаагч нарт зориулсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандарт” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Мөн шинээр томилогдсон албан хаагчдыг хүлээн авахдаа “Шинээр томилогдсон албан хаагчдын бүртгэлийн хуудас”-ыг нэвтрүүлж тэдний бүрдүүлбэл зохих баримт бичиг, заавал танилцсан байх хууль, дүрэм журмыг судлуулах зэрэг ажлын байран дахь сургалтыг Төрийн захиргааны удирдлагын газарт 1-2 өдөр зохион байгуулж үндсэн газарт хүлээлгэн өгч хэвшээд байна.

Дотоодын их дээд сургуулийн докторын сургалтад 1 албан хаагч, магистрын сургалтад 5 албан хаагч, бакалаврын сургалтад албан хаагчийг тус тус суралцах боломж, нөхцөлөөр хангаж өгөөд байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны захиалгаар Сөүлийн Үндэсний Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн магистрын сургалтад, БНХАУ-ын Бээжингийн зам харилцааны их сургуулийн “Төмөр замын тээврийн менежмент”-ийн магистрын сургалтад, БНХАУ-ын Далианы далайн их сургуулийн Усан замын тээврийн эдийн засаг, менежментийн сургуулийн магистрын сургалтад суралцаж байсан 3 албан хаагч төгссөн.

БНХАУ-ын Зүүн өмнөдийн Их сургуулийн магистрын, Япон улсын Гифүгийн их сургуулийн авто замын хөрөнгийн менежментийн магистрын тэтгэлэгт сургалтад 1, Австрали улсын Гриффит их сургуулийн магистрын сургалтад 1, нийт 2 албан хаагч суралцаж байна.

“Мэдээллийн цаг”-ийн арга хэмжээний 2019-2020 оны төлөвлөгөөг 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 14 хоногт 1 удаагийн давтамжтайгаар 9 удаа тодорхой сэдвээр зохион байгуулсан.

7. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зохион байгуулсан ажил, үр дүн

“Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 74 дүгээр тушаалаар батлуулсан ба уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөний дагуу жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэв: Үүнд:

а/ Яамны төрийн захиргааны нийт 12 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр болон ахиулан олгох, төрийн үйлчилгээний 7 албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/42 дугаар тушаалаар шийдвэрлүүлэв.

б/ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны Б/18 дугаар тушаалаар төрийн захиргааны 49 албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгов.

г/ Албан хаагчдын ээлжийн амралт, тэтгэвэр, буцалтгүй тусламж олгох зэрэг асуудлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад шийдвэр, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байгаа ба 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 133 албан хаагчид ээлжийн амралтын олговор олгогдсон ба, 25 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгов.

д/ Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, албан хаагчид ажлын байран дээр эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг хангаж, эмчийн ажлын байрыг баталгаажуулан ажиллуулж байна.

е/ Хувиараа мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдад суралцах боломжийг хангаж, 6 албан хаагчид цалинтай чөлөө олгох асуудлыг шийдвэрлэсэн.

ж/ Албан хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэнд, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, долоо хоногт нэг удаа спорт зааланд тоглох боломжоор хангасан. Жингийн илүүдэлтэй, зүрх, судасны өвчтэй, даралт ихсэх өвчтэй албан хаагчдын судалгааг гаргасны үндсэн дээр нийт 28 албан хаагчийг фитнес клубт 70 хувийн хөнгөлттэйгөөр 3 сарын хугацаанд хичээллэх боломжоор хангасан.

з/ Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулах үүднээс өндөржүүлсэн бэлэн байдлын үед тээвэр зохион байгуулалтыг амжилттай зохион байгуулсан нийт 4 албан хаагчийг “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт хамруулсан.

и/ Гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдлын үед мэргэжлийн ур чадвар гаргаж, хүнд төвөгтэй даалгаврыг амжилттай биелүүлсэн

албан хаагчдыг холбогдох журмын дагуу 1 хүртэлх сарын цалингаар шагнаж, урамшуулсан.

8. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Зам, тээврийн хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн ажлын байрны жагсаалт, орон тоог Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 328 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Шинэчлэн батлагдсан ажлын байрны жагсаалт, орон тоонд нийцүүлэн тус яамны удирдах албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор зөвшөөрөл олгосон. Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 393 дугаар тушаалаар төрийн захиргааны удирдах албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан. Үүний дагуу нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж Төрийн албаны зөвлөлийн 24 дүгээр тогтоолоор нэр дэвшүүлэн ирүүлсний дагуу тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга нарыг томилох асуудлыг Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Б/27, Б/26, Б/28, Б/50 дугаар тушаалаар тус тус шийдвэрлэв. Мөн тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албаны даргын албан тушаалын сул орон тоог нөхөх нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж Төрийн албаны салбар зөвлөлийн 2020 оны 4 дүгээр тогтоолоор нэр дэвшүүлэн ирүүлсний дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Б/73 дугаар тушаалаар томилсон.

9.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Зам, тээврийн хөгжлийн яамны гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 56, 57,58 дугаар тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/36 дугаар тушаалаар баталсан. Үүний дагуу Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 03, 08 дугаар тогтоолоор тус тус шалгалтын комиссыг байгуулж тус яамны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн албан ёсны хуудсаар нээлттэй зарлаж, 2 удаа зохион байгуулсан. Шалгалтын комиссын тайлан, дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 4, 5, 6, 7, 9, 10, 11, 12, 13 дугаар тогтоолоор тус тус нэр дэвшүүлсний дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Б/73, Б/74, Б/75, Б/81, Б/88, Б/89, Б/87, Б/98, Б/101 тус тус томилов.

10.Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-д заасны дагуу тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс “...биеийн эрүүл мэндийн байдлын улмаас гурван сараас дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон, зургаан сараас дээш хугацааны сургалтаар (шинэ дадлага, туршлага эзэмшүүлэх сургалтыг оролцуулан) бэлтгэгдэх болсон, цэргийн жинхэнэ алба хаах болсон зэрэг мөн зүйлийн 46.1-т заасан үндэслэлээр захиргааны

санаачилгаар түр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц"-ийн сан бүрдүүлж, сангийн бүртгэл, бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг эрхлэн гүйцэтгэж байна.

Тус яамны төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд эрүүл мэндийн байдлаас төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 10, сургалтад хамрагдах зорилгоор төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 22, төрийн өөр албан тушаалд томилогдож чөлөөлөгдсөн 9 албан хаагч тус тус бүртгэлтэй байна.

11. Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах, дүгнэх ажлыг мэргэшлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцсон байдал

Зам, тээврийн хөгжлийн сайд Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсантай холбоотойгоор газар, хэлтсийн дарга нар Төрийн нарийн бичгийн даргатай 01 дүгээр сарын 19-ний дотор, нэгжийнхээ албан хаагчидтай 01 дүгээр сарын 24-ний дотор гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хувийг Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлэхийг газрын дарга нарт үүрэг болгосны дагуу тус яамны нийт албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Сахилга хариуцлага, хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгох зарлах тухай" 01 дүгээр тушаалд байгууллагын удирдах албан тушаалтны манлайллыг идэвхжүүлж, тэдний зүгээс хуульд нийцээгүй шийдвэр гаргах, удирдан зохион байгуулах үйл ажиллагааг сулруулах, цаг ашиглалт хангалтгүй байх, хууль бус шаардлага тавих зэрэг аливаа сөрөг үйлдэл, нөлөөллийг албан хаагчдад үзүүлэхгүй байх, удирдах албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг хариуцсан байгууллага, нэгжийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбон авч үзэж, хариуцлага тооцож байхыг үүрэг болгосны дагуу энэ асуудлаар Хөдөлмөрийн дотоод журмыг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 296 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэхдээ нэгжийн даргын үнэлгээтэй уялдуулан дүгнэх талаар Төрийн нарийн бичгийн даргаас чиглэл өгсний дагуу 2020 оны I, II, III, IV дүгээр улирлын дүнг үнэлэхдээ газар, хэлтсийн дарга нарын үнэлгээг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас үнэлсний дараа албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх ажлыг зохион байгуулж байна.

12. Ёс зүйн зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч ажилласан байдал, үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6.1-д "Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл /цаашид "Ёс зүйн зөвлөл" гэх/ төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дэргэд ажиллана" гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн "Ёс зүйн зөвлөл байгуулах тухай" 196 дугаар тушаалаар Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх "Ёс зүйн зөвлөл"-ийг байгуулан ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг Ёс зүйн зөвлөлийн дарга Н.Бат-Эрдэнээр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ёс зүйн зөвлөлийн зарим гишүүдийн ажил үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 20-ны

өдрийн “Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах тухай” А/49 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Мөн “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын төслийг боловсруулж, яамны албан хаагчдаас санал авч, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах тухай” А/49 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан бөгөөд уг журмыг байгууллагын цахим хуудсанд байршуулж сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, хандлага, харилцааны талаар сургалт зохион байгуулах зорилгоор “Хууль -эрх зүй” сэдэвт сургалтын төлөвлөгөөг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.

Тайлангийн хугацаанд албан хаагчдын ёс зүйтэй холбоотой гомдол ирээгүй болно.

13. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн

Байгууллагын болон хүний нөөцийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгжийн болон холбогдох асуудлыг хариуцсан албан хаагчийн үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж байгаа ба энэ нь мэдээллийг байгууллагын цахим хуудас, дотоод удирдлагын системийг ашиглан нээлттэй мэдээлж байгууллагын гаднах болон дотоод хэрэглэгчдэд хүргэх, иргэдийн хүссэн мэдээллийг биечлэн болон албан бичиг, утсаар өгөх, цахим хуудсанд болон саналын хайрцагар санал, хүсэлтийг хүлээн авах зэрэг арга хэлбэрээр хэрэгжиж байна.

Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны хүрээнд тус яамны үйл ажиллагааны зорилго, зорилт, ажлын байр, тус яаманд ажиллаж байгаа албан хаагчдын нэрс, тэдгээрийн хариуцсан чиг үүргийн талаарх болон сул орон тооны мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлж байгаа бөгөөд хүний нөөцтэй холбоотой тушаал шийдвэр, хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зэрэг байгууллагын дотоодод чиглэсэн мэдээллийг дотоод удирдлагын Able програмд байршуулан албан хаагч нарт хүргэж байна.

Хүний нөөц болон салбар зөвлөлийн ажлын чиглэлээр дараах мэдээ, мэдээллийг цахим хуудсанд шинээр болон шинэчлэн байршуулав.

- 1) Яамны албан хаагчдын нэрс, утасны жагсаалт,
- 2) Зам, тээврийн хөгжлийн яамны 2020 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө,
- 3) Хүний нөөцийн ил тод байдал буланд “Хүний нөөцийн стратеги” дэд цэсийг ажилуулж, Төрийн албаны хүний нөөцийн стратегийг тодорхойлсон “Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-ийг цахим хуудсанд байршуулсан.
- 4) Төрийн албаны тухай хуулийн 33.6-д заасны дагуу “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг, мөн эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөг байршуулсан.
- 5) “Албан хаагчдын ёс зүй” гэсэн хэсэгт Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2020 01 дүгээр тушаалыг цахим хуудсанд байршуулсан.

Тус яамны сул орон тоотой холбоотой мэдээллийг тус яамны цахим хуудсанд байршуулж, сул орон тоог нөхөх зарыг тухай бүр тус яамны цахим хуудас болон Төрийн албаны зөвлөлийн хуудсанд байршуулан ажиллаж байна.

14. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, мэдээ ирүүлсэн байдал

Төрийн албаны зөвлөлийн өгсөн зааврын дагуу Хүний нөөцийн шинэ системд яамны албан хаагчдын мэдээллийг шивж оруулан, мэдээллийг хянаж, нэгтгэлийн дүнг тулган зөрүүтэй мэдээллийг засварлаж, цалин, зэрэг, дэв, нэмэгдэл, урамшуулалтай холбоотой мэдээллийг шинэчилж, улмаар төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг эцэслэж Төрийн албаны зөвлөлд хүлээлгэн өгсөн болно.

15.Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг, даалгаврын биелэлт

Энэ оны эхний хагас жилд Төрийн албаны зөвлөлөөс тус яам болон салбар зөвлөлд хандаж нийт 17 албан бичиг ирснээс Төрийн албаны зөвлөлийн тогтоол, сургалтанд оролцуулах тухай 5, хяналт-шалгалт хийх тухай 1, тайлан, судалгаа авах тухай 3, иргэнтэй холбоотой асуудлаар 3, бусад асуудлаар 5 албан бичиг тус тус ирсэн байна.

Эдгээр тогтоол, албан бичгээр өгсөн үүргийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллаж, хариу мэдээлэл, тайлбар, томилсон шийдвэр зэргийг тухай бүр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Тухайлбал Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд даргаар ажиллаж байсан С.Манлайг албан тушаалаас нь чөлөөлсөнтэй холбоотой холбогдох мэдээ, тайлбарыг тухай бүр гаргаж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус яамны төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг батлуулсны үндсэн дээр томилгоо хийх чиглэлийг Төрийн албаны зөвлөлөөс өгсөн. Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх ажлын хүрээнд тус яамны чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны шинжилгээг тус тус хийж Зам, тээврийн хөгжлийн яамны Стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 358 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. Үүний дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн ажлын байрны жагсаалт, орон тоог Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 328 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Шинэчлэн батлагдсан ажлын байрны жагсаалт, орон тоонд нийцүүлэн тус яамны гүйцэтгэх албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 56, 57, 58 дугаар тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/36 дугаар тушаалаар баталсан.

Тус яамнаас болон салбар зөвлөлөөс тайлант хугацаанд нийт 16 албан бичгийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлснээс сул орон тооны захиалга хүргүүлэх 3, хариу тайлбар хүргүүлэх тухай 3, санал хүргүүлэх 1, тайлан, судалгаа, биелэлт хүргүүлэх 3, бусад асуудлаар 6 албан бичгийг тус тус явуулсан болно.

Төрийн албаны зөвлөлийн өгсөн удирдамж, чиглэлийн дагуу ажлын хэсэг гарч Нийслэлийн авто замын хөгжлийн газар, Нийтийн тээврийн үйлчилгээний газарт тус тус хүний нөөцийн чиглэлээр шалгалтыг хийсэн бас тайланг Төрийн албаны зөвлөлд 2020 оны 03/441 албан тоот бичгээр хүргүүлсэн.

16. Дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хувьд 2020 онд төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх, төрийн албаны

тухай хууль, холбогдох журамд заасны дагуу албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан баталж, албан тушаалд томилохдоо төрийн албаны мерит зарчмыг баримтлан ажилласан.

Мөн салбарын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэл олон ажлыг зохион байгуулж, хүний нөөцийн томилгоо, албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалт хөгжлийн дэмжсэн бодлогыг хэрэгжүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн зүгээс албан хаагчдын шинэ санал, санаачлагыг дэмжих хүрээнд уралдаан тэмцээнийг зохион байгуулж, урамшуулал олгосон.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, суралцах боломжоор хангах үүднээс албан хаагчдыг мэргэшил дээшлүүлэх зорилгоор дотоод, гадаадын их дээд сургуульд гэрээний үндсэн суралцах боломжоор хангасан.

Мөн 4 албан хаагчийг хөнгөлттэй нөхцөлөөр орон сууц худалдан авах ажилд дэмжлэг үзүүлж, 50 гаруй албан хаагчдыг зуслангийн газартай болох ажлыг зохион байгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг албан хаагчдад ил тод нээлттэй байх зорилгоор улирал бүр хамт олны хуралдааны үеэр салбарын зөвлөлийн үйл ажиллагааг дүгнэж, цаашид анхаарах асуудлуудын талаар танилцуулгыг хийж хэвшээд байна.

Холбогдох хууль, журамд заасны дагуу салбар зөвлөлөөс тусгай шалгалтыг зохион байгуулж, төрийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

Зам, тээврийн хөгжлийн яамны
2021 оны 01 сарын 16 ны өдрийн тоот
03/196 бичгийн нэгдүгээр хавсралт

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

111246063 5919487 СЕТ19313

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах нэгж, албан тушаалтан	Биелэлт	Биелэлтийн хувь
1.	Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай, төсвийн шууд захирагч менежер болон төрийн жинхэнэ албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах	Хугацаа 4 дүгээр сард	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг зохих журмын дагуу бүх шатанд байгуулж, баталгаажуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай, төсвийн шууд захирагч менежер болон төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулсан. Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирал бүр дүгнэн ажиллаж байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр хангалттай сайн дүгнэгдсэн албан хаагчдыг Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д заасны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Б/68 дугаар тушаалаар нэгдүгээр улирлын урамшуулал олгосон.	100%
2.	Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд тус тус хяналт-	11 дүгээр сард	Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нийгмийн хангах хөтөлбөр, сургалтын	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал зөвлөмжийг боловсруулж хүргүүлсэн.	100%

	шинжилгээ, үнэлгээ хийж, санал зөвлөмж гаргах		хөтөлбөрийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж өгсөн байна.			
3.	Яамны төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын албан тушаалын хянаж, тодорхойлолтыг боловсруулах, шинэчлэн ажлыг зохион батлуулах ажлыг зохион байгуулах.	Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтод нийцүүлсэн байна.	Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтод нийцүүлсэн байна.	Зам, тээврийн хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн ажлын байрны жагсаалт, орон тоог Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 328 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Шинэчлэн батлагдсан ажлын байрны жагсаалт, орон тоонд нийцүүлэн тус яамны гүйцэтгэх албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 56, 57, 58 дугаар тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/36 дугаар тушаалаар баталсан.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга	100%
4.	Яамны төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох саналыг боловсруулж, шийдвэрлүүлэх	Журамд заасан шаардлага хангасан албан хаагчид зэрэг дэв бүрэн олгогдсон байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга	Албан хаагчдын төрийн албанд болон тухайн албан тушаалд ажилласан жилийн судалгааг гаргаж тавигдах шаардлагыг хангасан нийт 49 албан хаагчдад төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгуулах саналыг Төрийн албаны салбарын зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж	2 дугаар сард	100%

					Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчдад зэрэг дэв олгуулах асуудлыг Сайдад санал болгосон. Уг тогтолыг үндэслэн 2020 оны Б/18 дугаар тушаалаар Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох болзол шаардлага хангасан нийт 49 албан хаагчдад зэрэг дэв олгуулах асуудлыг шийдвэрлэв.		
5.	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Жилдээ	Хөтөлбөрийг судалгаанд үндэслэн бодитой, үндэслэлтэй, үр дүнд хүрэх тодорхой зорилт, арга хэмжээг тусган боловсруулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулсан, төлөвлөгөөний хэрэгжилт жилийн байдлаар 86.6 хувийн биелэлттэй байна.	100%	
6.	Яамны төрийн албан хаагчдын бүртгэл судалгааг хөтөлж, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан болон холбогдох бусад тайлан мэдээг гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Хагас, бүтэн жилд	Яамны төрийн албан хаагчдын мэдээллийг тухай бүр баяжуулж, мэдээллийн санг бүрдүүлсэн байна. Тайлан мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга	Тус яамны төрийн албан хаагчдын мэдээллийг тухай бүр баяжуулж, мэдээллийн санг шинэчилж байна.	100%	
7.	"Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнуулах албан хаагчийг тодруулж, ТАЗСЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Хагас, бүтэн жил	Газар, хэлтсээс нэр дэвшүүлж, ТАЗСЗ-өөр хэлэлцүүлж, шалгарсан албан хаагчийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж, ТАЗСЗ-д хүргүүлсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга	Холбогдох журмын дагуу шагналд нэр дэвшүүлэх албан хаагчийн материалыг бүрдүүлсэн. Хугацаа хоцорсон.	30%	

8.	Яамны албан хаагчдын 2020 оны сургалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах	Жилдээ	Албан хаагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга	Зам, тээврийн хөгжлийн яамны болон харьяа байгууллагын албан хаагчдыг 2020 онд сургах сургалтын төлөвлөгөө яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгдүгээр хавсралтаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт зохион байгуулагдсан 9 төрлийн сургалтад 52 албан хаагчийг хамруулсан байна.	100%
